



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/21.

Улаанбаатар хот

Замын зардал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албан тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.2, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолын 5^б заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.38 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явсан тус Төвийн Ахлах диспетчер-инженер Д.Бауыржанд ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашины энгийн үнэлгээгээр тооцож олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 160.000 /нэг зуун жаран мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Оюунжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

215030008Z